

ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН 2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэлийн хувь
Стратеги төлөвлөгөөний зорилго 1							
Зорилт-1 Эрүүл мэндийн салбарын удирдлага, зохион байгуулалтыг оновчтой болгон, сайн засаглал, ил тод байдлыг дэмжих							
1.1	Эрүүл мэндийн тухай хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөө болон Эрүүл мэндийн салбарын 2022-2025 оны стратеги төлөвлөгөөнд тусгагдсан үйл ажиллагааг орон нутгийн хэмжээнд хэрэгжүүлэн гэрээний үр дүнг Захиалагчийн өмнө хариуцна.		Хэрэгжилтийн хувь	75%	80%	2025 онд Эрүүл мэндийн тухай хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө болон Эрүүл мэндийн салбарын 2022-2025 оны стратеги төлөвлөгөөнд тусгагдсан үйл ажиллагааг орон нутгийн хэмжээнд хэрэгжүүлэн ажиллаж байна. Эрүүл мэндийн байгууллагуудын дунд хугацааны /2021-2025 оны/ бодлогын баримт бичиг “Стратеги төлөвлөгөө”-г 10 зорилт, 82 арга хэмжээний хүрээнд 90,1 хувьтай хэрэгжүүлсэн байна.	90
1.2	Төрийн албаны тухай хуулийн 53 дугаар зүйл, Засгийн газрын 2020 оны 216 дугаар тогтоолын дагуу харьяалах Эрүүл мэндийн байгууллагын дунд хугацааны бодлогын баримт бичиг Стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийг хангахад дэмжлэг үзүүлж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана.	-	Хэрэгжилтийн хувь	80%	83%	Эрүүл мэндийн байгууллагуудын дунд хугацааны /2024-2028 оны/ бодлогын баримт бичиг Стратеги төлөвлөгөөг Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлал, урт, дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг болон Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр зэрэг бодлогын баримт бичгүүдэд дэвшүүлсэн зорилго, зорилтуудтай уялдуулан шинэчлэн боловсруулж байна.Хэрэгжилтийн хувь-80%	80
1.3	Харьяалах нутаг дэвсгэрийн эрүүл мэндийн байгууллагын удирдах ажилтныг хууль журмын дагуу	-	Сонгон шалгаруулал таар	Томилогдсон удирдах ажилтан-3	Тухай бүр	Харьяа эрүүл мэндийн байгууллагын удирдах ажилтанг шинээр томилсон томилгоо 2025 оны эхний хагас жилийн байдлаар байхгүй байна.	100

	сонгон шалгаруулалтаар томилж, хүний нөөцийн тогтвортой байдлыг хангана.		томилогдсон удирдах ажилтны тоо				
1.4	Өөрийн харьяа нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа эрүүл мэндийн байгууллагын хүний нөөцийн хангалт, тогтвортой байдалд анхаарал хандуулж нийгмийн баталгаа, ажиллах нөхцөлийг дэмжиж ажиллана.	Улсын төсөв	Дутагдалтай эмч мэргэжилтний тоо	Сувилагч-17 Их эмч-13	Сувилагч-10 Их эмч-8	2025 оны эхний хагас жилийн байдлаар АНЭ- их эмч-5 Өрх сумын ЭМТ-их эмч-10 Сувилагч, тусгай мэргэжилтэн-28 ХНЭ их эмч- 4 Сувилагч, тусгай мэргэжилтэн-3 тус тус дутагдалтай ажиллаж байна. Дутагдалтай хүний нөөцийг бүрдүүлэх, давтан сургах, чадавхижуулах зорилгоор Аймгийн Засаг даргын санаачилгаар хэрэгжүүлж буй орон нутгийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн хүрээнд эрүүл мэндийн салбарт дутагдалтай хүний нөөцийг бүрдүүлэх, мэргэжлийн боловсон хүчнийг бэлтгэх, давтан сургах, чадавхижуулах зорилготой “ЗӨГИЙН ҮҮР” хөтөлбөрийн хүрээнд нийт 16 эмч,29 сувилагчийг сургаж байгаа бөгөөд 4 их эмч, 1 эм зүйч, 29 сувилагчийн 1 жилийн сургалтын төлбөрт 52,1 сая төгрөг зарцуулсан байна.2025 оны 6 сард 29 сувилагч, 2 их эмч, төгсөж гэрээний дагуу аймаг орон нутагт дутагдалтай байгаа ажлын байранд ажиллана.	50
1.5	Үйл ажиллагааны төсвийн зарлагын хэмнэлт, зардлын бүлэг хооронд шилжүүлэн зарцуулах зохицуулалтыг Төсвийн тухай хуулийн 42, 45, 46 дугаар зүйл, заалтын дагуу Захиалагчид бичгээр хүсэлт гаргаж шийдвэрлүүлнэ.	Улсын төсөв	Гүйцэтгэлийн хувь	2 удаа зардал хооронд өөрчлөлт хийгдсэн байна.	Гүйцэтгэлээр	Эрүүл Мэндийн Газрын даргын 302 тоот бичгээр 13 сумын ЭМТөв 221.1 сая төгрөг, АНЭмнэлгийн 85,0 сая төгрөг нийт 306.1 сая төгрөгийн зардлын бүлэг хооронд гүйлгэх санал хүсэлтийг хүлээн авч Эрүүл мэндийн яамны СДХэлтэст хүргүүлсний дагуу төсвийн хуваарьт 2 удаа өөрчлөлт орж нийт 221.1 сая төгрөгийн зарцуулах эрх олгогдсон.	100
1.6	Хэрэгжүүлэгч нь Захиалагчийн үйл ажиллагаатай уялдуулан жилийн санхүүжилтийн төсвийн төсөлд оруулах хөрөнгө оруулалтын		Давхцал үүссэн /тоо/	Давхцал үүсээгүй.	Төсвийн төсөлд хөрөнгө оруулалтын давхцал	Төсвийн төсөлд хөрөнгө оруулалтын давхцал үүсээгүй байна.	90

	талаар 2 тал харилцан тохиролцон аливаа нэг давхцал үүсгэхгүй байна.				үүсээгүй байна.		
1.7	Эрүүл мэндийн байгууллагуудын өр, авлагын байдалд хяналт тавин ажиллаж Төсвийн тухай хуулийн 6.2, 6.3, 6.4 болон 16.5.2, 16.5.3, 16.5.5, 57.5-д заасныг мөрдлөг болгон өр, авлага үүсгэсэн орон нутгийн эрүүл мэндийн байгууллагын Ерөнхий менежертэй хариуцлага тооцож тооцсон талаарх тайлангаа тухай бүрт нь Төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлнэ.	-	Өр авлага буурсан байна./хувиар /	Үүссэн өр 2.2 тэрбум	10-20 хувиар бууруулна	2025 оны 05 сарын төсвийн гүйцэтгэлийн мэдээгээр Эрүүл мэндийн байгууллагууд нийт.2.420.441.1 мянган төгрөгийн өртэй ажиллаж байна. Нийт өрийн 91.3 хувь буюу 2.210.743.1 мянган төгрөг АНЭмнэлгийн өр эзэлж байна. Өрийг эдийн засгийн ангилалаар авч үзвэл НДШ-286,8 сая төгрөг, ХХОАТатвар-64.1 сая төгрөг, эм, эмнэлгийн хэрэгсэл-1 тэрбум 800 сая төгрөг, бусад зардал-39.2 сая төгрөг байна. ЭМГазраас өрийг бууруулахад анхаарч Эрүүл мэндийн газрын зөвлөлийн хурлаар Нэгдсэн эмнэлгийн төсөв санхүүгийн мэдээллийг хэлэлцэж хугацаатай албан даалгавар зөвлөмжийг хүргүүлж өглөг бууруулах төлөвлөгөө боловсруулан ажиллах чиглэлийг өгч ажилласан. Үүний үр дүнд өмнөх онд үүссэн өр 910.1 сая төгрөгөөр буурсан байна. Мөн Төсвийн тухай хуулийн дагуу өр үүсгэсэн төсвийн шууд захирагчийг ЭМГДаргын Б/35 дугаар тушаалаар хариуцлага тооцон ажилласан	70
1.8	“Төсвийн тухай” хуулийн 8.9.2 дахь заалтын дагуу орон нутаг дахь эрүүл мэндийн байгууллагуудын төсвийн гүйцэтгэл, санхүүгийн жилийн тайланг Эрүүл мэндийн газраар нэгтгэн гаргуулж, аудит хийлгэн дараа оны 3 дугаар сарын 5-ны өдрийн дотор төсвийн ерөнхийлөн захирагчид ирүүлнэ.	-	ТЕЗахирагчийн харьяа ЭМБайгууллагуудын тайлан /26/	Хугацаанд хүргүүлсэн байгууллагын тоо /26/	100%	Эрүүл мэндийн сайдын 2025.02.04-ний өдрийн 7/621 албан тоотын дагуу Эрүүл мэндийн газрын даргын 156 албан тоотыг холбогдох эмнэлгүүдэд хүргүүлж 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг нэгтгэн аудитын дүгнэлтийг гаргуулж хуулийн хугацаанд ЭМЯамны СДХэлтэст хүргүүлж ажилласан.	100
1.9	Төсвийн тухай хуулиар эрүүл мэндийн сайдын багцад батлагдсан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний санхүүжилтийг эрүүл мэндийн яамны хөрөнгө оруулалтын дансаар дамжуулж	-	Санхүүжилтийн хувь	100%	100%	2025 оны хагас жилийн байдлаар Хэрлэн сумын жишиг өрхийн эмнэлэг, Цэнхэрмандал, Бэрх СЭМТөвийн барилгын өргөтгөлийн санхүүжилт 3.9 тэрбум төгрөгийг эрүүл мэндийн яамны хөрөнгө оруулалтын дансаар	100

	санхүүжүүлнэ.					дамжуулан санхүүжүүлж байна.	
1.10	Эрүүл мэндийн сайдын багцаас аймгийн засаг дарга нарт эрх шилжсэн ажлын явцын мэдээллийг сар бүр Эрүүл мэндийн яаманд дараа сарын 05-ны өдрийн дотор хүргүүлж байна.	-	Эрх шилжсэн ажлын явцын мэдээллийг хугацаанд нь хүргүүлсэн байна.	Мэдээллийг тогтмол хүргүүлсэн.	Мэдээллийг тогтмол хүргүүлсэн байна.	Эрх шилжсэн хөрөнгө оруулалтын ажил байхгүй болно .	100
1.11	Хэрэгжүүлэгч нь хагас жилээр эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанарын үзүүлэлтийн биелэлтийг 06 дугаар сарын 15-ны дотор; бүтэн жилээр гэрээний Гуравдугаар зүйлд тусгагдсан үйл ажиллагаа тус бүрийн биелэлт, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанарын үзүүлэлтийн биелэлт, төсвийн гүйцэтгэл, хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний хэрэгжилтийг жилийн эцсийн байдлаар дараа оны 01 дүгээр сарын 15-ны дотор Төсвийн ерөнхийлөн захирагчид ирүүлнэ.	-	Биелэлтийг хугацаанд хүргүүлсэн байна.	Тогтмол хугацаанд нь хүргүүлсэн.	Тогтмол хугацаанд нь хүргүүлсэн байна.	Аймгийн Засаг даргын гэрээний эрүүл мэндийн тусламж үйлчилгээний шалгуур үзүүлэлтийн биелэлтийг 2025 оны хагас жилийн байдлаар гаргаж хугацаанд нь хүргүүлсэн.	100
1.12	Эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотойгоор үүссэн өр авлагыг барагдуулан шинээр өр үүсгэхгүй, санхүүгийн сахилга баттай ажиллах		Өр,авлагын хэмжээ /хувиар/	-	Өр авлага тодорхой хувиар буурсан байна.	Улиралд 1 удаа зарцуулах эрхийн хүсэлт өгсөн эмнэлгүүдийн саналыг FISCAL төлөвлөлтийн программд оруулж ЭМЯ-ны СДХэлтэст хүргүүлэн зарцуулалтын эрхийг тавьж шинээр өр үүсгэхгүйгээр ажиллаж байна. Нэгдсэн эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой үүссэн өмнөх оны эмийн өр 960.1 сая төгрөгийн өрийг барагдуулсан ба ЭМСайдын 2025.03.12-ны өдрийн 1а/1231 албан даалгаврын хэрэгжилтийг ханган ажиллаж байна.	90
1.13	Эрүүл мэндийн байгууллагын барилгыг шинээр ашиглалтад оруулсан тохиолдолд хуучин барилгыг эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд ашиглахгүй байх. Монгол улсын засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын	Улсын төсөв	Санхүүжилтийг шийдвэрлэсэн байдал/төгрөг /	1.7 тэрбум төгрөг	2 тэрбум	Хагас жилийн байдлаар шинээр ашиглалтанд орсон эмнэлгийн барилга байгууламж байхгүй болно. Цэнхэмандал, Бэрх сумын ЭМТөвүүдийн барилгын өргөтгөл, /ХэрлэндОМ/ жишиг өрхийн эрүүл мэндийн төвийн барилгын ажлууд тус тус хийгдэж байна.	100

	тухай хуулийн 20.1.18, 21.1.16 дахь заалтын дауу төрийн өмчит эрүүл мэндийн байгууллагын барилга байгууламж, засвар үйлчилгээний ажлын санхүүжилтийг бүрэн шийдвэрлэн ажиллана.						
1.14	Баг, сумын эрүүл мэндийн төвийн эмч нарыг дулаан хувцсаар хангах, сумын эрүүл мэндийн төвийн автомашины засвар үйлчилгээг шийдвэрлэн ажиллана	УТөсөв ОНХС	Зарцуулсан төсөв төгрөг/	8 сая	12 сая	5 СЭМТөвүүд 6,8 сая төгрөгийг ажиллагсдын нормын хувцас, зөөлөн эдлэлийн зардалд зарцуулж ажилласан. Мөн Галшар, Баянхутаг, Батширээт СЭМТөвүүд түргэн тусламжийн автомашины засвар үйлчилгээнд 9,1 сая төгрөгийг тус тус зарцуулан ажилласан байна	100
Зорилт.2 Эмнэлгийн тусламж үйлчилгээг сайжруулан ажиллах							
2.1	Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд “Эрүүл мэндийн үйлчилгээнд тавих шаардлага” MNS7014:2023 стандартыг эрүүл мэндийн байгууллага бүрт хэвшүүлэх, сурталчлах арга хэмжээг хэрэгжүүлэн хэрэгжилтэд хяналт тавин ажиллана.	УТөсөв ОНХС	ЭМБ-дад хүргүүлсэн зөвлөмжийн тоо	4	8	“Эрүүл мэндийн үйлчилгээнд тавих шаардлага” MNS 7014:2023 стандартыг хэрэгжүүлэх, сурталчлах зорилгоор “Манлайлал” сэдэвт сургалтыг цахимаар 2 удаа зохион байгуулж, Эрүүл мэндийн байгууллагуудын ажилчдын 98%-г хамруулж сургалтын дараах дэмжлэгт хяналтыг 16 ЭМБайгууллагад хийж хэрэгжилтэд хяналт тавьж, 2 удаагийн зөвлөмж хүргүүлж ажилласан.	90
2.2	Сумдад анхан шатны тусламж, үйлчилгээний мобайл технологийг нэвтрүүлнэ.	Улсын төсөв	Мобайл технологийг нэвтрүүлсэн ЭМБ-ын тоо	12	2-оор нэмэгдүүлнэ	ЭМСайдын 2024 оны А/246 дугаар тушаалын дагуу Баянхутаг, Батноров, Баянмөнх, Галшар, Өлзийт сумуудад мобайл технологийг нэвтрүүлсэн ба нийт 12 байгууллага мобайл технологиор хангагдаж иргэдэд үзүүлэх тусламж үйлчилгээний чанарыг сайжруулж ажиллаж байна.Шинээр 2 ЭМТөвд Мобайл технологийг нэмэгдүүлэх саналыг ЭМЯаманд хүргүүлсэн	95
2.3	Өрхийн эрүүл мэндийн төвтэй байгуулах гүйцэтгэлийн гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн биелүүлж, өрхийн эрүүл мэндийн төвийн үйл ажиллагааны гүйцэтгэлд тогтмол	Улсын төсөв	ӨЭМТөвүүдийн гүйцэтгэлийн гэрээний биелэлт дундаж	86.9%	90%-иас доошгүй хувьд хүргэнэ.	Эрүүл мэндийн сайдын 2024 оны А/122 дугаар тушаалын дагуу Хэрлэн сумын тамгын даргаар ахлуулсан ажлын хэсэг томилогдон өрхийн эрүүл мэндийн төвүүдийн гүйцэтгэлийн гэрээний биелэлтийг хагас бүтэн жилээр үнэлдэг.	90

	хяналт тавьж ажиллана.		хувиар			ӨЭМТөвүүдийн үйл ажиллагаанд явцын хяналт үнэлгээг 2 удаа хийж арга зүйн зөвлөмж өгч ажилласан. Мөн эрүүл мэндийн сайдын 2020 оны А/179 дүгээр тушаалын дагуу ЭМХТөвийн магадлан итгэмжлэлийн албанаас шинжээчдийн баг томилогдон 3 өрхийн эрүүл мэндийн төвийг магадлан итгэмжилсэн. ЭМД-тай сар бүр гэрээг шинэчлэж гүйцэтгэлээр санхүүжилт олгогдон ажиллаж байна.Гэрээний хэрэгжилтийг 06 сарын 15-ны дотор үнэлнэ.	
2.4	Анхан шатны тусламж, үйлчилгээ үзүүлэгч өрх, сумын эрүүл мэндийн төвөөс үзүүлэх гэрийн эргэлт, архаг өвчний хяналтын үзлэгийг чанаржуулж гүйцэтгэлд хяналт тавина.	-	Гэрийн эргэлтийн хувь	70%	80%-аас доошгүй хувьд хүргэнэ.	Гэрийн эргэлт, хяналтын үзлэгийг өргөжүүлэн тусламж, үйлчилгээний хүлээгдэл, чирэгдлийг бууруулах зорилгоор сум, өрхийн ЭМТ-үүд төлөвлөгөөт ажлын хүрээнд давхардсан тоогоор 568 удаагийн гэрийн эргэлт, хяналтын үзлэгийг хийж тусламж үйлчилгээний хүлээгдэл, чирэгдлийг бууруулж, гэрийн эргэлт болон байнгын хяналтанд шаардлагатай иргэдийн 62.4%-д нь хүрч ажилласан байна.	80
2.5	Орон нутагт түр оршин суугч, явуулын иргэдэд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг харьяалал харгалзахгүй түргэн шуурхай үзүүлнэ.	-	Явуулын иргэдэд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлсэн тоо	Явуулын 4860 иргэнд тусламж үйлчилгээ үзүүлсэн	Шаардлагатай тохиолдолд тухай бүр	Аймгийн хэмжээнд отор нүүдлээр болон төвийн багт түр оршин суугч 2310 иргэн байгаа ба тэдгээрт амбулаторийн үзлэг, алсын болон ойрын дуудлага, хэвтэн эмчлүүлэх, багийн төвүүдэд улирал тутам явуулын амбулатори байгуулж эмнэлгийн тусламж үйлчилгээг давхардсан тоогоор 1100 гаруй иргэнд тусламж үйлчилгээг тасралтгүй чирэгдэлгүй үзүүлж байна.	80
2.6	Эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой халдварын сэргийлэлт аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааг дэмжиж ажиллана.	-	Халдварын сэргийлэлт аюулгүй байдал хяналт үнэлгээ хийсэн ЭМБ-ын тоо	12	17	Хагас жилийн байдлаар давхардсан тоогоор нийт 24 эрүүл мэндийн байгууллагад эмнэлгийн тусламж, үйлчилгээний халдварын сэргийлэлт, хяналтын чиглэлээр дэжлэгт хяналт хийж, зөвлөмж хүргүүлсэн. Мөн ЕБС-ийн 1 дүгээр ангийн сурагчдын шүдний үзлэгтэй холбоотой хувийн хэвшлийн 4 эмнэлэгт халдварын сэргийлэлт,	100

						хяналтаар үнэлгээ хийж, зөвлөмж хүргүүлсэн. Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар аюулгүй байдлыг сайжруулах, халдварын сэргийлэлт хяналтын үйл ажиллагааг дэмжих зорилгоор Эрүүл мэндийн хөгжлийн төвийн мэргэжилтнүүдтэй хамтран “Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, үйлчлүүлэгчийн аюулгүй байдлыг сайжруулах нь” сэдэвт 2 өдрийн танхимын сургалтыг зохион байгуулсан. Сургалтад нийт 122 эмч, эмнэлгийн мэргэжилтэнүүдийг хамруулж чадавхижуулсан.	
2.7	Жирэмсний эрт үеийн хяналтын хамрагдалтыг нэмэгдүүлэн жирэмсэн үеийн гурвалсан халдвар (ХДХВ, тэмбүү, гепатитын В,С вирус)-ын илрүүлэг шинжилгээний хамрагдалт, тэмбүүтэй жирэмсэн эмэгтэйн эмчилгээ, эмчилгээний дараах хяналт, бэлгийн хавьтагчийн илрүүлэлт, оношилгоо эмчилгээний байдалд байнга хяналт тавьж төрөлхийн тэмбүүгийн тохиолдол гаргахгүй ажиллана.	УТХО	Жирэмсний эрт үеийн хяналтын хувь	94.4%	95%-аас дээш хувьд хүргэнэ	Жирэмсний хяналтанд шинээр 482 жирэмсэн эмэгтэйчүүд хамрагдсан ба 95.2 хувь нь эхний 3 сартайдаа хяналтанд орсон байна. Хяналтанд орсон жирэмсэн эмэгтэйчүүдийн 93.2 хувь нь цусны шинжилгээнд хамрагдсан ба цус багадалттай 3 жирэмсэн бүртгэгдсэн байна. Шинээр хяналтад хамрагдсан жирэмсэн эмэгтэйчүүдээс трихомониаз илрүүлэх шинжилгээнд 377 буюу 78.2 хувь, заг хүйтэн илрүүлэх шинжилгээнд 377 буюу, 78.2 хувь, тэмбүү илрүүлэх шинжилгээнд 476 буюу 98.7 хувь, эерэг-2, ХДХВ/ДОХ илрүүлэх шинжилгээнд 476 буюу 98.7 хувь тус тус хамрагдсан байна. Хагас жилийн байдлаар төрөлхийн тэмбүүгийн тохиолдол бүртгэгдээгүй. Эхийн эндэгдэлгүй ажилласан.	100
2.8	"Төрөх насны эмэгтэйчүүдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлж, дутуу төрөлтөөс сэргийлэх" арга хэмжээг зохион байгуулж, Эх, нялхас, 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл, ялангуяа сэргийлж болох эндэгдлийг тууштай бууруулах чиглэлээр тэгш хүртээмжтэй чанартай тусламж үйлчилгээг зохион байгуулж, эх, хүүхдийн эндэгдэлд судалгаа хийж, хариу	УТөсөв ОНХС	5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэлийн түвшин	22.1 промилль	15.4 промилль	АЗДМХөтөлбөрт тусгагдсан “Эх хүүхдийн эрүүл мэндийг дэмжиж, сэргийлж болох хүүхдийн эндэгдлийг бууруулах” арга хэмжээг үе шаттайгаар хэрэгжүүлэн ажиллаж байна. АЗД-ын 2025.03.20-ны А/149 дүгээр захирамжийг үндэслэн ЭМГ-ын даргын 2025.04.16-ны өдрийн А/19 тоот тушаалын хэрэгжилтийн хүрээнд “Төрөх насны эмэгтэйчүүдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлж, дутуу төрөлтөөс сэргийлэх” бүсчилсэн	100

	арга хэмжээ хэрэгжүүлэн үр дүнг тооцон ажиллана.					сургалтыг урд болон зүүн бүсийн сумдад зохион байгууллаа. Тус сургалтаар өсвөр насны -175 охид, нөхөн үржихүйн насны-357, жирэмсэн-64, хөхүүл ээж-113 нийт-892 эмэгтэйчүүдэд эрүүл мэндийн боловсрол олгов. Сургалтын дараа нийт-4 нярай, 7 жирэмсэн ээжийг нарийн мэргэжлийн эмчийн үзлэгт хамрагдуулж зөвлөгөө өгч ажиллаа. Сургалтын өмнө оролцогчдыг судалгаа бөглүүлж эрүүл мэндийн мэдлэгийг үнэлэв. Сургалтад оролцогчдын сэтгэл ханамж 100% үнэлэгдсэн. Хагас жилийн байдлаар тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн 5 тохиолдол бүртгэгдсэн ба 1000 амьд төрөлтөд 11.9 промилль байгаа нь өмнөх оны мөн үеэс 4 тохиолдлоор буюу 8.1 промилиор буурсан үзүүлэлттэй байна.	
2.9	Эрүүл насжилтыг дэмжих олон нийтийн арга хэмжээг зохион байгуулна.	-	Зорилтот бүлгийн хамрагдалт	20%	40%	Ахмадын хороотой хамтран ахмад настны тулгамдсан асуудал, эрүүл урт насжилтын талаар 19 ЭМБ-дад танхимын сургалт зохион байгуулж нийт 1161 ахмад настанд эрүүл амьдралын хэв маяг, дасгал хөдөлгөөн, өвчнөөс урьдчилан сэргийлэх талаар мэдээлэл, зөвлөгөө өгч ажилласан. Зорилтот бүлгийн 8802 ахмад настны 13,1%-ийг хамруулсан.	70
2.10	Аймгийн нэгдсэн эмнэлгийн ахмад настны кабинетэд гериатр эмч, сувилагчийг орон тоогоор ажиллуулна.	-	Эмч, сувилагчийн тоо	Эмч 1	Сувилагч 1	АНЭ-ийн дарга, хүний нөөц, Сувилахуйн алба, ахмадын эмчтэй уулзаж, орон тооны сувилагчтай болгох, ахмадын эмчийг хавсран ажиллахгүй байх боломжийг хангах, ахмад настанд цогц үнэлгээг хийх багаж материал, тоног төхөөрөмж шаардлагтай зэргийг санал болгож ярилцсан.	50
2.11	Өрх, сумын эрүүл мэндийн төвд 9, 18, 36 сартай хүүхдийн эрүүл мэнд, хөгжлийн цогц үзлэгийг тогтмол зохион байгуулж, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн	-	Зорилтот бүлгийн хүүхдүүдийн хамрагдалт	97%-ийг хамруулсан	100%-д хүргэнэ	Аймгийн хэмжээнд 9 сартай нийт 1342 хүүхдээс үзлэгт хамрагдсан 983 буюу 73.2%, 18 сартай нийт 1593 хүүхдээс үзлэгт хамрагдсан 1409 буюу 88.5%, 36 сартай нийт 1889 хүүхдээс	80

	засах, хөдөлгөөн засах тусламж үйлчилгээг өргөжүүлж энэ чиглэлийн тусламж, үйлчилгээ үзүүлж байгаа эрүүл мэндийн байгууллагыг дэмжин ажиллана.					үзлэгт хамрагдсан 1441 буюу 76.3% байна. Хагас жилийн байдлаар зорилтот бүлгийн хамрагдалт 78.3 хувьд хүрсэн байна.АНЭ-т настны эмч-1 орон тоогоор ажиллуулж байна.Шинэ төгсөлтөөс кабинетийн сувилагчийг ажиллуулахаар төлөвлөөд байна.	
2.12	Жирэмсэн эмэгтэйн амь насанд ноцтой хүндрэл гарч зайлшгүй тээвэрлэх шаардлага үүссэн тохиолдолд онгоц болон бусад тээврийн хэрэгслийн зардлыг Засаг даргын нөөц хөрөнгөөс гарган дэмжлэг үзүүлнэ.	УТөсөв ОНХС	Тохиолдлын тоо	2024 онд тохиолдол гараагүй	Тохиолдол гаргахгүй ажилласан байна.	Аймгийн хэмжээнд 2025 оны хагас жилийн байдлаар нийт 420 эх төрсөн ба өнгөрсөн оны мөн үеэс 30 төрөлтөөр буюу 7.2 хувиар буурсан байна. Аймгийн нэгдсэн эмнэлэгт 379 буюу 90.2% нь төрсөн байна. Жирэмсэн эмэгтэйн амь насанд ноцтой хүндрэлийн улмаас зайлшгүй тээвэрлэх тохиолдол гараагүй.	100
2.13	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийлүүлэгдсэн томоохон тоног төхөөрөмжүүд болох Компьютерт томографын аппарат, Ангиографын аппарат, Хүчилтөрөгчийн бэсрэг үйлдвэр зэргийн засвар үйлчилгээ, сэлбэг хэрэгсэлд шаардлагатай төсвийг шийдвэрлэж, ашиглалт, аюулгүй ажиллагаа, хүний нөөцийн хангалт, сургалтад дэмжлэг үзүүлж ажиллана.	УТөсөв, ОНХС	Хэвийн үйл ажиллагааг хангахад зарцуулагдсан төсөв /төгрөг/	Хүний нөөцийг чадавхижуулахад 4,2 сая төгрөг зарцуулсан.	Шаардлагатай санхүүжилтийг тухай бүрт шийдвэрлэж ажилласан байна	Нэгдсэн эмнэлэгт улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 16 зүслэг бүхий компьютерт томографын аппаратаар хангагдсанаас хойш одоог хүртэлх хугацаанд нийт 2865 иргэнд оношилгоо хийж төвлөрлийг сааруулж, иргэдийн хүлээгдэл чирэгдлийг бууруулан ажилласан. Одоогоор тус аппарат эвдрэлтэй байгаа бөгөөд засварт 72 сая төгрөг шаардлагатай байгаа тул ЭМЯ, АЗДТГазрын удирдлагуудад танилцуулан асуудлыг шийдвэрлэхээр хүсэлтийг хүргүүлсэн. Ангиографийн аппаратын ашиглалт, аюулгүй ажиллагааг хангах инженер, мөн хавдрын хими эмчилгээний эмч, сувилагч, эм зүйч нарыг чадавхжуулах сургалтад хамруулан сургалтын төлбөрт дэмжлэг үзүүлсэн.	90
2.14	“Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль”-ийн 36.1.2-т заасны дагуу Төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагаас үзүүлэх тусламж үйлчилгээнд хэрэглэх эм, эмнэлгийн хэрэгслийн тооцоо, судалгааг гарган Эм, эмнэлгийн	Улсын төсөв	Эм, эмнэлгийн хэрэгслийн нөөцийн бэлэн байдал хувиар	Нөөцийн бэлэн байдал 80%	Нөөцийн бэлэн байдлыг 90 хувьд хүргэнэ	2025 онд худалдан авах эм, эмнэлгийн хэрэгслийг эрүүл мэндийн байгууллагуудын тусламж, үйлчилгээнд үндэслэн 17 багц болгон ангилж нийт 433,654,026 төгрөгийн төсөвт өртөгтэй нээлттэй тендер зохион байгуулахаар ЭМЯ-аар төлөвлөгөөг батлуулсан. Тендерийн сонгон шалгаруулалтаар 13 багц дээр нийт 9 компани шалгаран гэрээ байгуулан эм, эмнэлгийн	90

	хэрэгслийн хяналт, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад тогтоосон хугацаанд хүргүүлнэ.					хэрэгслийн нөөцийн бэлэн байдлыг 85%-тай ханган ажиллаж байна. 14 хоног тутам ЭЭХХЗГ-т нөөцийн болон тасралтын мэдээг хүргүүлж банья.	
2.15	Иргэдийн дунд сайн дурын авлагагүй донорын эгнээг өргөжүүлж аюулгүй цус, цусан бүтээгдэхүүний бэлдмэлийн хангамжийг нэмэгдүүлнэ	Улсын төсөв	Шинээр цусаа бэлэглэсэн сайн дурын донорын тоо	Шинэ донорын тоо 25	Шинэ донорын тоог 30-д хүргэнэ	Суурин хэлбэрээр 62, цувралаар 151 донороос 62.4л цус цусан бүтээгдэхүүн цуглуулсан. Цуглуулсан цус цусан бүтээгдэхүүнээр тасаг нэгжүүдийн захиалгын дагуу нийт 7 төрлийн 182 нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэж эмнэлгийн тусламж, үйлчилгээг сайжруулах бусдын амь насыг аврахад зориулсан бөгөөд яаралтай тусламж болон сэхээн амьдруулах эрчимт эмчилгээ, төрөх тасагт тохиолдсон ноцтой хүндэрлийн үед хэрэглэсэн. Сайн дурын донорын хөдөлгөөнийг өргөжүүлэх, иргэний оролцоог нэмэгдүүлэх үүднээс цахим болон танхимын хэлбэрээр нийт 520 гаруй иргэнд мэдээлэл хүргэж байнгын донорын хадгалалтын эзлэх хувийг 90%-д хүргэсэн. Мөн ажлын байран дээрх сургалтыг 3 удаа явуулж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, 15 донорыг шинээр элсүүлсэн.	90
2.16	Эмнэлгийн тусламж, үйлчилгээний төвлөрлийг сааруулах зорилгоор төрөлжсөн мэргэжлийн тусламж үзүүлэх Үндэсний багийг орон нутагт ажиллах нөхцөлийг ханган байр, хоол, унааны зардлыг шийдвэрлэн ажиллана	-	Үндэсний багийн гишүүдийн байр, хоол, унааны зардлыг шийдвэрлэсэн байна	2 удаагийн байр, хоол, унааны зардлыг шийдвэрлэсэн	Тухай бүрд	Нэн шаардлагатай тусламж, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, төвлөрлийг сааруулах зорилготой Үндэсний багийн 8 гишүүн хагас жилийн байдлаар нэг удаа 5 хоногийн хугацаатай ирж ажилласан бөгөөд тухайн хугацаанд байрласан байр, хоол, унааны зардлыг АЗДТГазартай хамтран бүрэн шийдвэрлэж ажилласан.	100
2.17	Хөгжлийн бэрхшээлтэй иргэн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авах дэд бүтцийг сайжруулан, тэдний мэдээлэл авах эрхийг хангах зорилгоор шат, баррель үсэг, зам, дуут санамжийг нэвтэрүүлэхэд	-	ХБИргэдэд тусламж үйлчилгээ үзүүлэх орчинг сайжруулж ажилласан	7	10	Эрүүл мэндийн байгууллага бүр хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд тусламж үйлчилгээ авах нөхцөл боломжийг сайжруулан иргэнд ээлтэй орчин бүрдүүлэх зорилгоор гадна талын тэргэнцэрт зориулсан зам, бариул тэмдэг тэмдэглэгээ болон	80

	хяналт тавин ажиллах.		ЭМБ-ын тоо			эмнэлэг доторх тусгай тэмдэглэгээг сайжруулж, дуугүй хөтөчийг байрлуулах, хөтөч сувилагчийг тогтмол ажиллуулах зэрэг зохион байгуулалтыг хийж ажиллаж байна. Хагас жилийн байдлаар 5 байгууллага баррель үсэгийн самбар байрлуулсан.	
2.18	Эмийн чанар, аюулгүй байдал, бүртгэл, цахим хяналтын тогтолцоог бий болгох	УТөсөв ОНХС	Мэдээллийн сан үүсгэсэн ЭМБ-уудын тоо	0	30	Антибиотик мэдрэг чанар, тэсвэржилт, бичил биетний эмийн зарцуулалт, үүнээс тарилга эмэнд эзэлж буй хувь зэрэг мэдээллийг агуулсан цахим мэдээллийн сан үүсгэж эхлэсэн бөгөөд одоогоор 6 эрүүл мэндийн байгууллага мэдээллийн сан үүсгэн ажиллаж байна. Аймгийн хэмжээнд 2025 оны 4 дүгээр сарын байдлаар хэвтэн эмчлүүлэгсэд 7084, үүнээс антибиотик мэдрэг чанар 740 үйлчлүүлэгчид тодорхойлоход пенциллиний бүлэгт тэсвэржилт үүссэн 78.8% байна. Мөн бичил биетний эсрэг эмийн зарцуулалт 25.1 хувь байгаа бөгөөд нийт хэрэглэсэн бичил биетний эсрэг эмийн 78% нь тарилгын хэлбрээр байна.	30
2.19	Сувилахуйн тусламж үйлчилгээнд “Эмчилгээ, оношлогооны түгээмэл үйлдэл MNS4621-2008 стандартыг эрүүл мэндийн байгууллага бүрт тогтмол хэрэгжүүлэх хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана.	Улсын төсөв	Сувилагч нарын гардан үйлдлийн ур чадварын үзүүлэлт	92%	94 %	Сувилахуйн тусламж үйлчилгээнд “Эмчилгээ, оношлогооны түгээмэл үйлдлийн MNS4621-2008 стандарт, болон аюулгүй тарилгыг баримтлан ажиллах зөвлөмжийг өгч ажилласан. Хасаг жилийн байдлаар магадлан итгэмжлэлд хамрагдах болон бусад эрүүл мэндийн нийт 11 байгууллагад давхардсан тоогоор 17 удаагийн хяналт, үнэлгээг хийхэд стандартын хэрэгжилт 85%, аюулгүй тарилгын баримтлалт 80%-тай байгаа ба сувилагч нарын гардан үйлдлийн ур чадварыг сайжруулах чиглэлээр сургалт, нөлөөллийн арга хэмжээг үе шаттайгаар зохион байгуулан ажиллаж байна.	80
2.20	“Шинэ сувилагч хөтөлбөр”-ийг орон нутагт хэрэгжүүлнэ.		Хөтөлбөрт хамрагдсан сувилагч, эх баригчдын	0%	100%	“Сувилагч мэргэжилтний цогц чадамж”-ийг хөгжүүлэх, сувилахуйн эмнэлзүйн хэлэлцүүлэг хийх талаар Жайка ОУСургалтад эрүүл мэндийн	30

			хамрагдалтын хувь			байгууллагуудын нийт 20 мэргэжилтэн хамрагдаж, шинэ сувилагч хөтөлбөрийг хэрэгжүүлэх, дадлагжуулах сургагч багшаар бэлтгэгдсэн. 2025 оны шинэ төгсөгчдийн судалгааг гаргаж сургалтад хамруулах ажлыг зохион байгуулахаар бэлтгэл ханган ажиллаж байна.	
2.21	Уламжлалт анагаах ухааны тусламж үйлчилгээг орчин үеийн анагаах ухаантай хослуулан хөгжүүлнэ.	-	УАУНЭ-ийн сургалтын танхимыг түшиглэн зохион байгуулсан сургалтад хамрагдсан иргэдийн тоо	1100	2200	Монголын нэгдмэл анагаах ухааны нийгэмлэгээс нөлөөллийн баг бүрдүүлж, “Уламжлалт анагаах ухааны тусламж үйлчилгээг орчин үеийн анагаах ухаантай хослуулан хөгжүүлэх” сэдэвт сургалтыг бүсийн хэмжээнд 2 удаа, эрүүл амьдралын хэв маягийг төлөвшүүлэх, өвчнөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр иргэдэд тогтмол зөвлөмж, мэдээлэл хүргэн ажиллаж нийт давхардсан тоогоор 1214 эмч, эмнэлгийн мэргэжилтэн, иргэдийг хамруулсан.	90
2.22	Эрүүл мэндийн байгууллагуудыг Магадлан итгэмжлүүлнэ.	Улсын төсөв	Магадлан итгэмжлэгдсэн байгууллагын тоо	12 ЭМБ	17 ЭМБ	ЭМСайдын А/179 дүгээр тушаалын шалгуур үзүүлэлтийн дагуу аймгийн хэмжээнд эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй 8 эрүүл мэндийн байгууллагыг магадлан итгэмжлүүлэхээр төлөвлөгөөний дагуу ЭМХТөвөөс томилогдсон 8 хүний бүрэлдэхүүнтэй шинжээчийн баг томилогдон 3 ӨЭМТ, 3 СЭМТ, 1 ТЭМТөв, 2 Рашаан сувилаллыг тус тус магадлан итгэмжлэлийн үнэлгээнд хамруулан Эрүүл мэндийн сайдын А/141 дүгээр тушаалаар магадлан итгэмжлэгдсэн.	100
Зорилт-3 Хүн амд эрүүл мэндийн боловсрол олгож, эрүүл зан үйл, аж төрөх хэв маягийг төлөвшүүлэх замаар зонхилон тохиолдох өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг эрчимжүүлэх.							
3.1	Үндэсний хэмжээнд эрүүл мэндийн чиглэлээр хэрэгжиж байгаа “Эрүүл Монгол хүн”, “Иргэний эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх” арга хэмжээнүүдийн хүрээнд хүн амын дунд эрүүл хэв маягийг төлөвшүүлэх чиглэлээр сургалт	Улсын төсөв, ОНТөсөв	Хэрэгжилтийн хувь	25%	30%	Хэнтий аймгийн хэмжээнд хагас жилийн байдлаар “Осол гэмтлээс сэргийлэх 0-5 насны хүүхдийн аюулгүй орчин” сарын аян, “Хорт хавдрын эсрэг анхаарал хандуулах сарын аян”, “Дархлаажуулалтын 10 хоног”, “Дэлхийн тамхигүй өдөр”, “24/3 шүдээ зөв угаа” сарын аян нийтдээ 5	80

	сурталчилгааг иргэн, аж ахуйн нэгж байгууллага, төрийн ба төрийн бус байгууллагуудтай хамтран зохион байгуулна.					чиглэлийн арга хэмжээний хүрээнд 6 сэдвээр Эрүүл мэндийн газраас иргэдэд 47, Анхан шатны эрүүл мэндийн байгууллагаас иргэдэд 192 удаагийн танхимын сургалтыг зохион байгуулан насан хүрсэн 3991 иргэд олон нийт, өсвөр насны 3462 хүүхдүүдэд эрүүл мэндийн боловсролыг хүргэн ажилласан. Мөн цахим хуудсаар дамжуулан дундажаар 17044 иргэд олон нийтэд мэдээ мэдээлэл хүргэсэн.	
3.2	Нас, хүйс, эрүүл мэндийн эрсдэлд суурилсан урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг үзлэгийг /сургуульд суурилсан эрт илрүүлэг, хавдрын эрт илрүүлэг/ орон нутагт зохион байгуулж харьяа нутаг дэвсгэрийн хүн амыг хамруулна.	Улсын төсөв, ОНТөсөв	Хамрагдалтын хувь	20%	30%	Засгийн газрын 2024-2028 оны мөрийн хөтөлбөрт тусгагдсан “6 настны нүд, шүд, зүрхний өвчний эрт илрүүлэг үзлэг”-т хамрагдвал зохих 1686 хүүхдээс 1446 /85.7%/ хүүхэд хамрагдсан байна.	100
3.3	Засгийн газрын 2023 оны 322 дугаар тогтоолоор батлагдсан “Эрүүл шүд” арга хэмжээг орон нутгийн хэмжээнд зохион байгуулж алслагдсан сумдад амны хөндийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг өргөжүүлэн үзлэг оношилгоо, эмчилгээний явуулын баг ажиллуулж санхүүжилтийн хувьд дэмжлэг үзүүлж ажиллана.	Улсын төсөв, ОНТөсөв	Хэрэгжилтийн хувь	20%	30%	“Эрүүл шүд” арга хэмжээний хүрээнд 17 сургууль, 34 цэцэрлэг хэрэгжүүлэн шүд угаах цагийг бий болгон хэвшүүлэн ажиллаж байна. 2025 оны 1 дүгээр сард багш ажилчдын санаачилгаар Хэрлэн 5, Хан Хэнтий, Тэмүүжин сургуулиуд шүд угаах орчныг сайжруулж тохижуулалт хийгээд байна. “24/3 шүдээ зөв угаа” аяны хүрээнд Ерөнхий боловсролын сургуулийн 35 бүлгийн 1247 суралцагчдад “Амны хөндийн эрүүл мэнд” сэдвийн хүрээнд сургалт нөлөөллийн ажлыг зохион байгуулж цахим хуудсаар дамжуулан 23690 иргэд олон нийтэд мэдээ мэдээлэл хүргэн ажилласан. Мөн Засгийн газрын 2024-2028 оны мөрийн хөтөлбөрт тусгагдсан “6 настны нүд, шүд, зүрхний өвчний эрт илрүүлэг үзлэг”-ийн хүрээнд Аймгийн хэмжээнд шүдний урьдчилан сэргийлэх үзлэг оношилгоонд 1688 хүүхэд хамрагдахаас хагас жилийн байдлаар 832 /49.2%/ хүүхэд хамруулсан байна.	100
3.4	“Сэтгэцийн эрүүл мэнд” арга	Улсын	Бэлтгэл	25%	30%	“Архидан согтуурахаас сэргийлэх	100

	хэмжээг хэрэгжүүлэн сэтгэцийн эрүүл мэндийг хамгаалах, ялангуяа өсвөр үеийнхэнд хорт зуршил, электрон тамхи, мансууруулах сэтгэц нөлөөт бодисын хор хөнөөл болон осол гэмтлээс урьдчилан сэргийлэхэд салбар дундын хамтын ажиллагааг өргөжүүлнэ.	төсөв ОНХС ОНТ	ажлын шалгуурын биелэлтийн хувь			сарын аян", "Эрчүүдийн эрүүл мэндийг дэмжих 7 хоног", "Дэлхийн тамхигүй өдөр"-ийн хүрээнд аймгийн хэмжээнд 16 эрүүл мэндийн байгууллага салбар хоорондын хамтын ажиллагааг өргөжүүлэн Хүүхэд хамгааллын нийгмийн ажилтан, Цагдаагийн газар, Боловсролын газартай хамтран 10-17 /9862/ насны өсвөр үеийнхэнд чиглэсэн сургалт нөлөөллийн ажлыг зохион байгуулж 1230 сурагчдыг танхимын сургалтад хамруулан цахим хуудсаар дамжуулан 3210 /45%/ иргэд олон нийтэд мэдээ мэдээлэл хүргэсэн.	
3.5	Анхан шатны эрүүл мэндийн байгууллагад ХБӨ/ЗСӨ-өөс сэргийлэх, хянах нэн шаардлагатай тусламж, үйлчилгээний багцын (МонПЭН) тусламж үйлчилгээнд хяналт тавьж, дэмжлэг үзүүлж ажиллана.	Улсын төсөв, ОУ-ын төсөл, хөтөлбөр	Үзлэгийн хамрагдалтын хувь	20%	25%	Анхан шатны 21 ЭМБ-ын 45 эмч мэргэжилтнүүд ХБӨ/ЗСӨ-ний нэн шаардлагатай тусламж үйлчилгээний багц арга хэмжээг нэвтрүүлж халдварт бус өвчний эрт илрүүлэх хүндрэлээс сэргийлэх сургалтад хамрагдсан. Mncardio программ- нийт 1574 /22%/ хүнд эрсдлийн үнэлгээ хийж хяналтад аваад байна	100
3.6	Хүн амын дунд зонхилон тохиолдож байгаа сүрьеэ, бэлгийн замаар дамжих халдвар (БЗДХ)-т өвчнийг тандах, илрүүлэх, урьдчилан сэргийлэх үзлэгт зорилтот бүлгийг хамруулах арга хэмжээг төрийн болон төрийн бус байгууллага, ажил олгогчидтой хамтран зохион байгуулж, эмчилгээнд хамрагдалт, эмчилгээний үр дүнг улирал бүр хянана.	Улсын төсөв, төсөл, хөтөлбөр ,ОНТөсөв	Үзлэгийн хамрагдалтын хувь	80%	85%	Хагас жилийн байдлаар сүрьеэ, БЗДХ-ын илрүүлэг урьдчилан сэргийлэх үзлэгт 663 үйлчлүүлэгч хамрагдсанаас шинээр илэрсэн сүрьеэгийн 20, БЗДХ-ын 46 тохиолдол тус тус бүртгэгдэж эмчилгээ, хяналтад байна. Үүнээс сүрьеэгийн далд халдварын эмчилгээнд 15 иргэн хамрагдсан. Төрийн болон төрийн бус байгууллага ажил олгогчидтой хамтран аймгийн хэмжээнд 6 сум, 5 төрийн байгууллагын 280 орчим албан хаагч, эрсдэлт бүлгийн 315 иргэдэд Сүрьеэ, БЗДХ-ыг илрүүлэх үзлэг шинжилгээг зохион байгуулан ажилласан. Зорилтот бүлгийн иргэдийн 82%-ийг илрүүлэг үзлэг шинжилгээнд хамруулан ажилласан. Эмчилгээний хамрагдалт 100%.	100
3.7	Дархлаажуулалтын хамралтыг орон нутгийн түвшинд нэмэгдүүлнэ.	Улсын төсөв,	Хамрагдалтын хувь	96.3%	97%	2025 оны эхний хагас жилийн байдлаар Товлолийн дархлаажуулалтанд	95

		ОУ-ын төсөл, хөтөлбөр				БЦЖ 99.7%, 90%, Тавт 93.3, УГУ 92.6%, ВГА 92.3%, ПЭВ 92.4% тус тус хамрагдсан байна.	
3.8	Халдварт өвчний дэгдэлт, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үеийн бэлэн байдлан хангаж, хариу арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлэн, салбар хооронд хамтран ажиллах, эрүүл мэндийн байгууллагын тогтвортой байдлыг хангах төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлнэ.	Улсын төсөв, ОНТ ОУ-ын төсөл, хөтөлбөр	Төлөвлөгөөнд тодотгол хийсэн тоо	2 удаа тодотгол хийгдсэн.	Цаг үетэй холбоотой тухай бүр тодотгол хийнэ.	Улаанбурхан өвчний тархалтаас сэргийлэх, эмнэлгийн тусламж, үйлчилгээний бэлэн байдлыг ханган ажиллах, дархлаажуулалтыг зохион байгуулах тухай ЭМСайдын 2025 оны 08 дугаар албан даалгаврыг хэрэгжүүлэх төлөвлөгөөнд 2025 оны 03 дугаар сарын 27-ны өдөр нэг удаа тодотгол хийн ажилласан.	100
3.9	“Халдварт өвчнөөс сэргийлэх, хянах” арга хэмжээг хэрэгжүүлэн тандах, өвчлөлөөс сэргийлэх үйл ажиллагааг зохион байгуулна.	Улсын төсөв, ОНТ ОУ-ын төсөл, хөтөлбөр	Хэрэгжүүлсэн ажлын тоо /тандалтын тоо, хариу арга хэмжээний хувь, сургалтын тоо	35%	40%	Хагас жилийн байдлаар аймгийн хэмжээнд 329 цочмог халдварт өвчин бүртгэгдэж үүнээс 229 цочмог цэврүүт тууралттай хамшинж, 8 гар хөл амны өвчин бүртгэгдсэн. Улаанбурхан өвчний сэжигтэй тохиолдол 29 бүтгэгдсэнээр лабораторит 31 цус, ХЗА-ын 29 сорьцыг ХӨСҮТ-ийн вирус судлалын лабораторид хүргүүлсэнээс 11 тохиолдол батлагдсан. Үүнд хавьтлаар тогтоосон 285 хавьтлын 175-г нь голомтын үеийн дархлаажуулалтад хамруулж аймгийн хэмжээнд голомтын үеийн хариу арга хэмжээг 96.5%-тай авч хэрэгжүүлсэн. Улаанбурхан өвчнөөс урьдчилан сэргийлэх хариу арга хэмжээний 5 удаагийн сургалтад ЭМБ-ын 57 эмч, ажилчдыг хамруулсан.	100
3.10	“Орчны эрүүл мэнд” арга хэмжээг орон нутгийн түвшинд хэрэгжүүлж салбар дундын оролцоог хангаж ажиллана.	Улсын төсөв, ОНТөсөв	Хэрэгжилтийн хувь	20%	30%	Хагас жилийн байдлаар сумын 11 эрүүл мэндийн байгууллага, 4 өрхийн эрүүл мэндийн төвд эрүүл мэндийн байгууллагын ус ариун цэвэр, хог хаягдлын менежментийн чиглэлээр магадлан итгэмжлэлийн өмнөх дэмжлэгт хяналтаар ажиллаж алдаа дутагдалд зөвлөмж боловсруулан ЭМБ-уудад хүргүүлсэн. Мөн Эрүүл мэндийн байгууллагын аюултай хог хаягдлын мэдээ тайланг сар бүр нэгтгэж хяналт тавьж ажилласан. Хагас жилийн	100

						байдлаар Эрүүл мэндийн аюултай хог хаягдал 1тн 684кг бүртгэгдсэн байна. ХГБХХГ, Боловсролын газар, Цагдаагийн газартай хамтран “Бүх төрлийн тамхины хор нөлөө” сургалтад Хэрлэн сумын 1735 хүүхдийг хамруулсан. Мөн 16 Төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран “Орчны бохирдолоос урьдчилан сэргийлэх” аяныг зохион байгуулан хамтран ажилласан. Орчны эрүүл мэнд арга хэмжээний хэрэгжилт 27,2%-тай байна.	
3.11	Эрүүл ахуйн тухай хуулийн хэрэгжилтийг ханган эрүүл мэндийн байгууллагыг сайжруулсан ариун цэврийн байгууламжтай болоход дэмжлэг үзүүлж, 1-2 сумын эрүүл мэндийн төвийн ариун цэврийн байгууламжийг стандартын дагуу шинэчлэн ажиллана.	Улсын төсөв, ОУ-ын төсөл, хөтөлбөр	Стандарт хангасан ариун цэврийн байгууламжтай эрүүл мэндийн байгууллагын тоо	2 ЭМБ	2-оор нэмэгдүүлэх	Эрүүл ахуйн тухай хуулийн хэрэгжилтийг ханган эрүүл мэндийн байгууллагыг сайжруулсан ариун цэврийн байгууламжтай болоход дэмжлэг үзүүлж Өмнөдэлгэр сумын эрүүл мэндийн төв нь стандартын шаардлага хангасан ариун цэврийн байгууламжтай болсон.	100
3.12	Эрүүл мэндийн даатгалын хамралтыг нэмэгдүүлэх ялангуяа ядуу, эмзэг бүлгийн иргэд, малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчид, коллежийн суралцагчдын хамрагдалтыг нэмэгдүүлэх, талаар мэдээлэл, сурталчилгааны ажил тогтмол зохион байгуулна.	Улсын төсөв, ОНТөсөв	Хамрагдалтын хувь	30%	35%	Эрүүл мэндийн даатгалын хамралтыг нэмэгдүүлэх ялангуяа ядуу эмзэг бүлгийн иргэд малчид хувиараа хөдөлмөр эрхлэгч, их дээд сургууль, коллеж, мэргэжлийн сургалт үйлдвэрийн төвийн суралцагчдын хамрагдалтыг нэмэгдүүлэх зорилгоор 18 сумаас 14 сум 4 тосгоны 6697, аймгийн төвийн 5750 буюу зорилтот бүлгийн 30-50 насны иргэдийн 12447 /32.5%/-ийг 1 удаагийн тамхимын сургалтад хамруулсан.	100
Зорилт-4 Эрүүл мэндийн удирдлагын мэдээллийн нэгдмэл тогтолцоог хөгжүүлэх							
4.1	Алсын зайн анагаах ухаан, телемедицины үйл ажиллагааны тасралтгүй байдлыг хангах, тоног төхөөрөмж хурдны интернетээр ханган ажиллана.	Улсын төсөв	Тоног төхөөрөмж, хурдны интернетээр хангагдсан ЭМБ-ын тоо	Хурдны интернеттэй-25 телемедицин тэй-3	1 ЭМБ-ыг телемедицин тэй болгоно.	Бор-Өндөр сумын НЭ-ийг алсын зайн телемедицинийг сайжруулахад шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангахаар бэлтгэл ажил хийгдэж байна.	50
4.2	Кибер аюулгүй байдлын сургалтанд Лавлагаа шатлалын		Зохион байгуулсан	1 удаа зохион байгуулсан	4 удаа зохион	АЗДТГазар цахим хөгжлийн хэлтэстэй хамтран 4 удаа танхимаар,	100

	эрүүл мэндийн байгууллагын мэдээллийн технологийн ажилтан, статистик мэдээллийн ажилчдыг улирал бүр хамруулна.	Улсын төсөв	сургалтын тоо	.	байгуулсан байна.	Мөн зүүн бүсийн мэдээлэл технологийн инженерүүдэд цахим хөгжил, кибер аюулгүй байдлын сургалтад ЭМБ-ын мэргэжилтнүүд хамрагдсан. ЭМГазраас статистикч эмч нар болон Мэдээлэл технологийн инженерүүдэд 2 удаа цахимаар сургалт зохион байгуулж, 34 мэргэжилтэн хамрагдсан.	
4.3	Кибер аюулгүй байдлын тухай хуулийн 19.1.3 дахь заалтад Эрүүл мэндийн байгууллага нь онц чухал мэдээллийн дэд бүтэцтэй байгууллага гэж заасан тул эрүүл мэндийн мэдээллийн аюулгүй байдал, мэдээллийн системийн өдөр тутмын үйл ажиллагааг явуулахад шаардлагатай сервер, тоног төхөөрөмжөөр хангаж, эрсдэлийн үнэлгээ хийлгэж зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.	Улсын төсөв	Үнэлгээ хийлгэх. Шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангагдсан хувь	Серверээр хангагдсан ЭМБ-1	Шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангана Үнэлгээ хийгдсэн ЭМБ-ын тоо	Эрүүл мэндийн газар, Нэгдсэн эмнэлэг, Хөдөөгийн нэгдсэн эмнэлэгт эрдслийн үнэлгээг Тагнуулын хэлтэс, МХСүлжээ компани хийж байна.	100
4.4	Нотолгоонд тулгуурласан шийдвэр гаргах үйл ажиллагаанд эрүүл мэндийн байгууллага ялангуяа хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын мэдээ мэдээллийн үнэн зөв шуурхай байдлыг хангана.	-	Мэдээллийн үнэн зөв шуурхай байдлыг хангасан байна.	2024 онд сар бүр мэдээлж ажилласан, хүн амын өвчлөл эндэгдлийн мэдээллийн сан үүссэн, тайлан	Үнэн зөв шуурхай мэдээлсэн, тайланг хугацаанд нь тайлагнасан байна.	Эмч, мэргэжилтнүүдэд ОУӨвчний 10 дугаар ангиллын 4 тэмдэглэгээт код, үйлдлийн 9 дүгээр ангиллын кодлолтыг сайжруулах, бүртгэлийн маягтуудыг үйл ажиллагаандаа үнэн зөв хөтлөх, шинээр нэвтрүүлж буй wings, ds.hdc.gov.mn программын мэдлэг олгох сургалтыг цахимаар 1 удаа зохион байгуулж ажилласан. Сар бүрийн 4 ны дотор нийт 117 ЭМБайгууллагууд мэдээ тайланг хугацаанд нь өгч хэвшсэн. Холбогдох байгууллагуудад эргэн мэдээллээр хүргүүлэн ажиллаж байна.	100
4.5	Эрүүл мэндийн байгууллагад мэдээлэл технологийн техник хангамж, сүлжээ, програм хангамжийн дэд бүтцийг өргөжүүлэн бүх эрүүл мэндийн байгууллагын өндөр хурдны интернэт сүлжээнд холбоно.	Улсын төсөв	Цахимжуулалтын хувь	Цахимжилт 100%	Сайжруулалт 50%/	Худаг, сувагчлал 4 сараас нээгдсэн учраас Зоонозын өвчин судлалын төвийг шилэн кабельд холбох саналаа МХС, Мобикомд хүргүүлсэн. Мөн шаардлагатай тоног төхөөрөмжийг бэлэн болгосон.	50
4.6	Хавдрын эрт илрүүлэг, хавдарын					Хавдрын бүртгэл мэдээллийг Hinfo,	90

	бүртгэл, тандалтыг сайжруулна.	Улсын төсөв	Хавдрын эрт илрүүлгийн хувь	73%	75%	CanRegMon, Screening.mn программуудад мэдээллийн сан үүсгэн ажиллаж байна. Аймгийн хэмжээнд хавдрын хяналтанд 986 өвчтөн байгаагаас хагас жилийн байдлаар хорт хавдрын шинэ өвчлөл 68 тохиолдол бүртгэгдсэн. Үүнээс бүтцээр нь авч үзвэл 31.6% элэг, 12% ходоод, 7.2 % умайн хүзүү, 6.4 % уушги, 3.1% хөх, 2% бүдүүн гэдэсний хавдар эзэлж байна. Эрт үедээ 52.8%, хожуу үе шатандаа 47.2%-тай оношлогдсон. ХСҮТ-тэй хамтран ажиллах гэрээ байгуулсан. Орон нутагт хими эмчилгээг хийж эхлэхээр хүний нөөцийг бэлтгэж байна.	
4.7	Эрүүл мэндийн байгууллагуулын үйл ажиллагааг хянах, зөвлөн туслах, нэгдсэн удирдлагаар ханган ажиллах	Улсын төсөв	Эрүүл мэндийн байгууллагын тоо	9 ЭМБ	10 ЭМБ	Эхний хагас жилийн байдлаар ЭМГазрын хяналт үнэлгээний баг нь АНЭ, 4 өрхийн ЭМТ болон 6 сумын эрүүл мэндийн төвийн үйл ажиллагаанд хяналт үнэлгээг хийж зөвлөмжийг хүргүүлэн ажилласан. Үүнд: Сүрьеэгийн тусламж үйлчилгээ болон сорьц тээвэрлэлт, ХПВ эсрэг дархлаажуулалтын явцын болон Улаанбурханы дэгдэлтийн үеийн хариу арга хэмжээ бэлтгэл бэлэн байдалд, магадлан итгэмжлэлийн явцын үнэлгээг тус тус хийж ажилласан. Мөн Хэрлэн суманд үйл ажиллагаа явуулж буй 3 эмийн сан, 2 үүдэн эмнэлгийн үйл ажиллагаанд тус тус явцын хяналт үнэлгээ хийж, мэргэжил аргазүйн зөвлөгөө өгч ажилласан. Мөн зонхилон тохиолдох халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг болон эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой халдварын эрсдэл, халдвараас сэргийлэх хяналт, эмнэлгийн тусламж, үйчилгээний бодлогын хэрэгжилтэд дэмжлэгт хяналт үнэлгээг хийж	100

						зөвлөмжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажилласан.	
4.8	Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний нэгдсэн санг бий болгох, дүн шинжилгээ хийх	Улсын төсөв	Хэрэгжилтийн хувь	100%	100%	Эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой үүссэн тохиолдол, эрсдлийг бүртгэх журмын дагуу мэдээллийн нэгдсэн санг үүсгэн, бүртгэж, дүн шинжилгээ хийн ажиллаж байна. Хагас жилийн байдлаар нийт 14 тохиолдол, 4 эрсдлийг бүртгэн, дүн шинжилгээ хийж холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэн, тусламж, үйлчилгээний чанарыг сайжруулахад анхааран ажиллаж байна.	100
4.9	Эрүүл мэндийн мэдээ мэдээллийн сан бий болгох, нэгдсэн тоон мэдээллээр хангах	Улсын төсөв	Гүйцэтгэлийн хувь	100%	100%	Тайлант онд сүүлийн 10 жилийн /2014-2024 оны/ үзүүлэлтээр мэдээллийн санг үүсгээд баяжуулан ажиллаж байна. Мэдээллийн санг health.gov.mn, wings, ehealth, screening, canregmon эрт илрүүлгийн vhs.hinfo.mn програмуудад үүсгэн, ЭМХТ болон ГССҮТөв, ЭХЭМҮТөвийн тандалтын албанд тогтмол мэдээ мэдээллийг хүргэн ажиллаж байна. Хувийн хэвшлийн эрүүл мэндийн medee.1212.mn программд сар бүр үүдэн эмнэлэг-27, рашаан сувилал 3, эмийн сан 51 байгууллагын тайлан мэдээг авч мэдээллийн санг бүрдүүлэн ажилласан. 114 ЭМБайгууллагууд анхан шатны маягтуудыг 100% цахим бүрдүүлэн, мэдээ мэдээлэлд дүн шинжилгээ хийж, эргэн мэдээллээр хангаж mohs.khe.gov.mn сайтад байршуулан ажиллаж байна. Хандалтын тоо 5843	100
Зорилт-5 Хүний нөөцийг хөгжүүлэх бодлогыг хэрэгжүүлэх, хүний нөөцийн менежмент боловсронгуй болгох							
5.1	Эрүүл мэндийн ажилтны нийгмийн баталгааг сайжруулан, орон нутагт тогтвор суурьшилтай ажиллуулах чиглэлээр орон сууц, гэрээр хангах, малжуулах арга хэмжээ хэрэгжүүлнэ.	Улсын төсөв	Хамрагдсан хүний тоо	Малжуулсан - 2 Гэрээр хангасан-2	3 хүнийг малжуулна. 2 хүнийг гэрээр хангана.	20 сум тосгоны 23 их эмч, 9 сувилагч, 1 бага эмчийг эмчийн байраар хангасан. 2025 оны хагас жилд Галшар, Биндэр, Норовлин сумын ЭМТ шинээр ажилд орсон 3 их эмчийг байраар хангасан. Бор-Өндөр нэгдсэн эмнэлэг шинээр баригдаж буй орон сууцанд 2 эмчийг хөнгөлөлттэй нөхцлөөр хамруулахаар нутгийн удирдлагатай гэрээ	100

						байгуулсан. Биндэр сумын ЭМТ шинээр ажилд орсон 1 эмч, 1 сувилагчийг 50 толгой бог малаар малжуулсан. Өрх толгойлсон, өөрийн гэр оронгүй 2 сувилагчид гэр олгуулахаар орон нутгийн удирдлагуудад уламжлаад байна.	
5.2	Эрүүл мэндийн байгууллагын ажилтнуудыг ажиллангаа суралцан мэргэжил дээшлүүлэх, үндсэн болон төрөлжсөн мэргэшил эзэмших, мэдлэг, ур чадварыг тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн гадаад, дотоод сургалтад хамруулах болон эрүүл мэндийн удирдах ажилтнуудыг үе шаттайгаар бэлтгэн ур чадварыг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.	Улсын төсөв	Хамрагдсан эмч мэргэжилтний тоо	Мэргэшил эзэмшсэн их эмч, сувилагч тусгай мэргэжилтэн-23, Гадаад сургалтад хамрагдсан их эмч, сувилагч тусгай мэргэжилтэн-17	Мэргэшил эзэмших их эмч, сувилагч тусгай мэргэжилтэн - 24, Гадаад сургалтад хамрагдах их эмч сувилагч тусгай мэргэжилтэн -18	Төгсөлтийн дараах төрөлжсөн болон дээшлүүлэх мэргэшлийн хаврын сургалтын элсэлтэд их эмч-2, сувилагч -8. Ажиллангаа суралцах гэрээгээр их эмч-2, сувилагч-2, эм найруулагч-1 тус тус суралцаж байна. Эмнэлгийн мэргэжилтний мэдлэг ур чадварыг тасралтгүй хөгжүүлэхэд анхаарч : БНСУ-ын Намъянжу хотод байрлах Эль (EL) эмнэлэг, Жолла мужийн Чон-Жу хотод байрлах Хью Саранг, эмнэлэгтэй харилцан хөгжих зохилгоор 7 чиглэлд хамтын ажиллагаа солилцооны гэрээг байгуулж ажилласан бөгөөд гэрээний дагуу ЭМГ-1,АНЭ-5, УАУНЭ-1 эмч, эмнэлгийн мэргэжилтэн 7-21 хонгийн сургалтанд тус тус хамрагдсан байна. Цаашид гэрээний дауу эрүүл мэндийн байгууллагын дарга, эмч эмнэлгийн мэргэжилтнийг үе шаттайгаар богино хугацааны сургалтанд хамруулах, туршлага судлуулах ажлыг зохион байгуулж байна. Мөн ЭМХТ, Дадал сумын ЭМТ-тэй хийсэн. Төрийн санхүүжилтээр гадаадад суралцагчтай байгуулах гэрээний дагуу сумын эрүүл мэндийн төвийн 1 их эмч БНХАУ-ын ӨМӨЗО-ны Олон Улсын Монгол эмнэлгийн хороонд 3 сарын сургалтанд хамрагдсан.Нийт эмч мэргэжилтний 2.2% хамрагдсан байна.	90
5.3	Аймгийн Нэгдсэн эмнэлгийг ерөнхий мэргэшил судлалаар сургалт эрхлэх байгууллага болгон бэлтгэж, шаардлагатай хөрөнгө оруулалтыг шийдвэрлэж орон	Улсын төсөв	Бэлтгэл ажил хангагдсан /хувь/	30%	80%	Сургалтын танхимаар 40м2 хоёр тасалгаа өрөө, резидент эмч нарыг байрлуулах 3 өрөөг тохижуулах, тоног төхөөрөмжөөр хангах ажлыг гүйцэтгэж байна. Сургалтын албыг 3 хүний	50

	нутагтаа эрүүл мэндийн салбарын хүний нөөцийг мэргэшүүлэн бэлтгэнэ.					бүрэлдэхүүнтэй байгуулах асуудлыг нэгдсэн эмнэлгийн ТУЗ-ын хурлаар оруулж шийдвэрлүүлэхээр бэлтгэл ажлыг хангаж байна.	
Зорилт-6 Бодлогын баримт бичиг болон хуулиар олгосон чиг үүргийг хэрэгжүүлж, хяналт тавих							
6.1	Объектийн эрсдэлийн үнэлгээг үндэслэн их, дунд эрсдэлтэй үнэлэгдсэн нийт 72 объектод 5 хяналтын чиглэлээр төлөвлөгөөт шалгалт зохион байгуулах	Батлагдсан төсвийн хүрээнд	Хяналт шалгалтад хамрагдсан объектын /хувь/	92%	100%	Объектын эрсдэлийн үнэлгээг үндэслэн их, дунд эрсдэлтэй үнэлэгдсэн нийт 72 объектоос хагас жилийн хугацаанд 37 объектыг буюу хамруулж, 474 зөрчил илрүүлж үүний 296 буюу 62 %- ийг газар дээр нь арилгуулж бусад зөрчил дутагдлыг арилгуулахаар 238 заалт бүхий улсын байцаагчийн хамтарсан 17 албан шаардлага өгч, биелэлтэд хяналт тавин ажилласан.	100
6.2	Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 5 ² .1-д заасны дагуу иргэн, аж ахуйн нэгж байгууллагын, өргөдөл, хүсэлт, гомдол, мэдээллийн дагуу төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийх	Батлагдсан төсвийн хүрээнд	Өргөдөл, гомдолын шийдвэрлэлтийн хувь	100%	100%	Тайлант хугацаанд 7 өргөдөл, гомдол ирсэнээс 2-ийг нь харьяалалын дагуу Цагдаагийн газарт болон аймгийн Нэгдсэн эмнэлгийн ёс зүйн хороонд шилжүүлсэн ба 2 өргөдөлд холбогдох хяналтын чиглэлийн дагуу хяналт шалгалт хийж, илэрсэн зөрчил аргуулахаар 18 заалт бүхий 2 албан шаардлага өгч, зөрчлийн хэрэг нээж алдаа дутагдал гаргасан 1 эмчид сахилгын шийтгэл, 2 гомдолд хамаарах 2 ААНБ, 1 иргэнд Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулж, 6.300.000 төгрөгийн торгуулийн арга хэмжээ ногдуулж, эрх бүхий албан тушаалтаны албан даалгавар хүргүүлж, зөрчлийг арилгуулсан.	100
6.3	Хяналтын 5 чиглэлээр урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх	Улсын төсөв	Объектын хамрагдалтын тоо	192	Тухай бүр	Хяналтын 5 чиглэлээр ЭМЯ-ны СХГазрын даргын баталсан 11 урьдчилан сэргийлэх хяналт шалгалтын удирдамжийн хүрээнд нийт 58 объектод хяналт шалгалт хийсэн ба согтууруулах ундаа худалдах худалдааны газар, тамхи, тамхин бүтээгдэхүүн худалдаалах газрын ажлын байранд холбогдох хяналтын хуудсаар хяналт хийж, бага эрсдэлтэй	70

					үнэлэгдсэн 50 ААНБ, иргэнд ажлын байрны шаардлага хангасан дүгнэлт гаргасан. Согтууруулах ундаа худалдаалах болон түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл олгох комиссын бүрэлдэхүүнд 5 удаа ажилласан . Мөн тайлант хугацаанд ундны усны чанар, аюулгүй байдалд үнэлгээ, дүгнэлт өгөх зорилгоор 28 объектын 28 ундны усны дээжийг авч, стандарт хэмжилзүйн итгэмжлэгдсэн хими, нян судлалын лабораторит 420 үзүүлэлтээр шинжилгээг хийлгэхэд 2 дээжинд 2 үзүүлэлт эерэг дүнтэй гарсан. Хот суурин газрын хөрсний бохирдлын түвшинг үнэлэх зорилготой аймгийн тодорхойлсон 5 цэгээс 5 хөрсний дээж , Хэрлэн сумын Хэнтий-Ус ХХК-ийн харъяа цэвэрлэх байгууламжаас бохир усны дээж авч ХАНЛАБ ХХК-ийн итгэмжлэгдсэн лабораторит Хүрээлэн байгаа орчин. Усны чанар. Ариутгах татуургын сүлжээнд нийлүүлэх хаягдал ус. Ерөнхий шаардлага MNS 6561:2015 стандартын шаардлага хангасан эсэхэд хяналт хийлгүүлэхээр дээжийг хүргүүлсэн. Мөн Бор-Өндөр сумын нийтлэг үйлчилгээний харъяа цэвэрлэх байгууламжийн орох гарах хэсгээс бохир усны 2 дээж авч ХАБҮЛЛабораторит шинжилгээг хийлгэхээр хүргүүлсэн. Шинжилгээний хариу одоогоор гараагүй байгаа ба шинжилгээний хариуг үндэслэн арга хэмжээ авч ажиллана. Хэрлэн сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй 3 эм хангамжийн байгууллагын үйл ажиллагаанд урьдчилан сэргийлэх хяналтыг хийж, илэрсэн зөрчлийг арилгуулахаар 9 заалт бүхий 3 албан шаардлага хүргүүлэн, биелэлтэд хяналт тавин ажиллаж байна. Хяналт шалгалтын явцад удирдамжид тусгагдсан асуудлыг хянаж, хавсралт хүснэгтийн хүрээнд	
--	--	--	--	--	--	--

						мэдээллийг гаргаж ЭМЯ-ны СХГазарт хугацаанд нь хүргүүлсэн.	
6.4	Нийтийг хамарсан баяр ёслол, цаг үеийн шаардлагаар зохион байгуулж буй арга хэмжээнд урьдчилан сэргийлэх шалгалт хийх/цагаан сар, хүүхдийн баяр, шинэ жил, наадам/	Улсын төсөв	Хяналт шалгалтад хамрагдсан объектын тоо	173	Тухай бүр	Цагаан сар, хүүхдийн баярыг угтсан хяналт шалгалтыг ХХААГ-тай хамтран гүйцэтгэж, Хэрлэн, Бор-өндөр, Баянмөнх, Дархан, Мөрөн суманд хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч 218 ААНБ, иргэнийг хамруулсан. Шалгалтаар 33 нэр төрлийн 2171 ширхэг 9.750.510 мянган төгрөгийн үнэ бүхий хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг устгаж, лангуунаас татан авхуулсан. Мөн дутагдалыг арилгуулахаар 32 заалт бүхий 2 албан шаардлагыг хүргүүлж, биелэлтийг хангуулсан ба хоол хүнсний хордлого халдварын эрсдэлээс урьдчилан сэргийлэх 29 заалт бүхий зөлөмжийг 10 байгууллагад өгч, мэргэжил арга зүйгээр ханган, эрсдэлээс сэргийлэх арга хэмжээ авч ажилласнаар хоол, хүнсний хордлого халдвар гараагүй. Шалгалтын явцад Эвт зүүн бүсийн худалдааны төвийн 43 ажилтанд эрүүл ахуйн зохистой дадлын талаар танхимын сургалт зохион байгуулсан байна. Мөн “Хүүхэд бүр баяраараа эрүүл байх нь ээж аавын хараа хяналтаас шалтгаална” сэдвийн хүрээнд Өндөрхаан телевиз болон Аруухан сайтад ярилцлага өгсөн.	100
Зорилт-7 Бусад үйл ажиллагааны чиглэлээр							
7.1	Эрүүл мэндийн байгууллагыг цахилгааны тасралтгүй эх үүсвэрээр хангах, цахилгаан эрчим хүчний доголдлоос эмнэлгийн тоног, төхөөрөмж гэмтэх, цахилгааны богино холбоо үүсэх эрсдлээс сэргийлж дотоод хяналтыг тогтмолжуулж, цахилгааны нөөц эх	Улсын төсөв	цахилгааны нөөц эх үүсвэрийг шийдвэрлэсэн тоо	7 ЭМБ	Тухай бүр	Цахилгааны нөөц эх үүсвэрийн бэлэн байдлыг хангаж ажиллаж байна. 2-р улирлын байдлаар цахилгааны эх үүсвэр нэмэгдээгүй байна	100

	үүсвэрийн бэлэн байдлыг ханган ажиллана.						
7.2	Төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус, урьдчилан сэргийлэх хяналт шалгалтын дүнг Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцэн харьяалах нутаг дэвсгэрт эрүүл мэндийн чиглэлээр илэрч буй зөрчлийг арилгуулах, үүсэж болзошгүй эрсдэлээссэргийлэх, эрсдэлийг бууруулах чиглэлээр арга хэмжээ авч ажиллана.	Батлагдсан төсвийн хүрээнд	Хяналтад хамрагдсан объектын тоо	72 объект хамрагдсан.	Удирдамжийн хүрээнд заагдсан объектыг хамруулана.	Хагас жилийн хугацаанд 16 эрүүл мэндийн байгууллагад төлөвлөгөөт, 4 газарт иргэний өргөдөл, гомдолын хүрээнд төлөвлөгөөт бус, 1 хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагад урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг хийсэн. Төлөвлөгөөт шалгалтын явцад нийтлэг 212 зөрчил илрүүлж үүний 155 буюу 73.1 %- ийг газар дээр нь арилгуулж бусад зөрчил дутагдлыг арилгуулахаар 143 заалт бүхий улсын байцаагчийн хамтарсан 7 албан шаардлага өгч, биелэлтэд хяналт тавин ажиллаж байна. Төлөвлөгөөт болон урьдчилан сэргийлэх удирдамжуудын хүрээнд хяналт шалгалт бүрэн хийгдэж танилцуулга тоон мэдээ бүрэн гарсаны дараа хурлаар хэлэлцэх тул хугацаа болоогүй.	70
7.3	Харьяа нутаг дэвсгэрийн эрүүл мэндийн байгууллагад зайлшгүй шаардлагатай хөрөнгө оруулалт, бусад дэмжлэгийг Засаг даргын нөөц сан, Орон нутгийн төсвийн хөрөнгө, Орон нутгийн хөгжлийн сангаас шийдвэрлэх арга хэмжээ авч ажиллана.	Улсын төсөв	ОНХС-аас шийдвэрлэсэн хөрөнгө оруулалт/төгрөг/	400 сая	3 авто машин	Хагас жилийн байдлаар орон нутгийн Хөрөнгө Оруулалтаар Хэрлэн сумын 3 ӨЭМТөвд түргэн тусламжийн автомашин олгогдсон. Мөн ЗДНСангаас “Эрт илрүүлэг, эх хүүхдийн эрүүл мэнд төсөл” 24,8 сая төгрөг ЗДТТазраас 5.7 сая төгрөг, “Сүрье өвчний эрт илрүүлэг үйл ажиллагааг эримжүүлэх” 2.0, “ЭХЭМэндийг дэмжиж 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийг бууруулах” 40.0 гм нийт 72.5 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын дэмжлэгийг орон нутгаас шийдвэрлэсэн.	100
7.4	Эрүүл мэндийн чиглэлээр хэрэгжиж байгаа гадаадын зээл тусламж, олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавьж, дэмжлэг тусалцаа үзүүлнэ.		Төсөл хөтөлбөрийн тоо	2 төсөл хэрэгжсэн	Тухай бүр	НҮБ-ын Хүүхдийн сан хөтөлбөрийн хүрээнд “Эхийн сүүгээр хоололтыг дэмжих хөхний арчилгаа” төсөл “Хавдрын урьдчилан сэргийлэлт, эрт илрүүлгийн үндэсний сүлжээ байгуулах” Австри улсын ЗГ-ын хөнгөлттэй зээл төслийн хүрээнд нийлүүлэгдсэн 575.2 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг үндсэн хөрөнгөнд бүртгэж ашиглалтанд хяналт тавин ажиллаж байна.	100

7.5	Усны тухай хууль, Эрүүл ахуйн тухай хуулийн холбогдох заалтуудыг орон нутгийн хэмжээнд хэрэгжүүлэн хүн амыг чанар, аюулгүй байдлын шаардлага хангасан ундны усаар тогтвортой, хүртээмжтэй хангаж байгаа байдалд хяналт хийх, ариун цэврийн байгууламжийн аюулгүй байдлын төлөвлөгөө хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлнэ.	ОНТ	Арга хэмжээний тоо		Хөтөлбөр төлөвлөгөөг боловсруулсан байна	Ариун цэврийн байгууламжийн аюулгүй байдлын талаар 3 зорилт, 15 арга хэмжээ бүхий төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Нутаг дэвсгэрийнхээ хүн амын усан сан бүхий газрын усны эх үүсвэрийн хамгаалалтын болон эрүүл ахуйн бүсийн зааг, тэжээгдлийн бүсийн талаарх судалгааг Байгаль орчны газар болон холбогдох сумдаас авч байна. Мөн ундны усны чанар, аюулгүй байдалд лабораторийн шинжилгээтэй хяналтыг хийж мэргэжил арга зүйн зөвлөгөөг өгч ажиллаж байгаа ба стандарт хэмжилзүйн итгэмжлэгдсэн хими нян судлалын лабораторид 28 объектын 28 ундны усны дээжийг 420 үзүүлэлтээр шинжлүүлэхэд 2 дээжинд 2 үзүүлэлт эерэг гарсан дүнтэй байна.	100
7.6	Нутаг дэвсгэрийнхээ хүн амын усны сан бүхий газар, усны эх үүсвэрийн хамгаалалтын болон эрүүл ахуйн бүсийн зааг, тэжээгдлийн мужийг тэмдэгжүүлж, хамгаалах, бүсийн дэглэмийн хэрэгжилтийг хангаж ажиллана.	-	Хэрэгжилтийн хувь		30%	Нутаг дэвсгэрийнхээ хүн амын усан сан бүхий газрын усны эх үүсвэрийн хамгаалалтын болон эрүүл ахуйн бүсийн зааг, тэжээгдлийн бүсийн талаарх судалгааг Байгаль орчны газар болон холбогдох сумдаас авч, бүсийн дэглэмийн хэрэгжилтийг хангаж ажиллах чиглэлийг сумдын Засаг дарга нарт чиглэл өгч байна. Хэрэгжилт 50%	50
7.7	Эрүүл ахуйн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3-т “Барилга байгууламж барих газрын байршил тогтоох, барилгын зураг төсөл зохиох, барилга барих, ашиглалтад оруулах, өргөтгөх, зориулалтыг нь өөрчлөхөд эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар эрүүл ахуйн дүгнэлт гаргуулна” гэж заасны дагуу газар олгохтой холбоотой дүрэм, журамд өөрчлөлт оруулах замаар барилга	Батлагдсан төсвийн хүрээнд	Эрүүл ахуйн дүгнэлтийн тоо	27	Тухай бүр	Эрүүл ахуйн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3-т тусгагдсан заалтын хүрээнд зураг төсөлд хяналт хийж, улсын байцаагчийн 13 дүгнэлт гаргасан ба барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрмийн 2 дугаар хавсралтаар томилогдсоны дагуу 2 барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын гишүүний бүрэлдэхүүнд ЭАХХХУБайцаагч өөрийн чиглэлээр оролцож ажилласан.	100

	байгууламж барих газрын байршил тогтооход эрүүл ахуйн дүгнэлт гаргуулж байх нөхцөлийг бүрдүүлэхэд анхааран ажиллана.						
7.8	Хяналт үнэлгээний үндэсний хорооны 2024 оны 02 дугаар тогтоолоор батлагдсан Салбарын хяналтын 2025 онд хэрэгжүүлэх хяналт шалгалтын төлөвлөгөө, ЭМЯ-ны Салбарын хяналтын газрын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг харьяалах нутаг дэвсгэртээ хангуулж, хяналт шалгалтын дүнг Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцэж, харьяалах нутаг дэвсгэртээ илэрч буй зөрчил дутагдлыг арилгуулах, үүсч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах чиглэлээр бодлого зохицуулалтын арга хэмжээ авч ажиллана	Батлагдсан төсөв	Хамрагдсан объектын тоо	5 хяналтын чиглэлээр 72 объектод хамрагдсан.	72 объект хамруулсан байна.	Хагас жилийн хугацаанд төлөвлөгөөт хяналт шалгалтад 37 объектыг хамруулж, 474 зөрчил илрүүлж үүний 296 буюу 62 %-ийг газар дээр нь арилгуулж бусад зөрчил дутагдлыг арилгуулахаар 238 заалт бүхий улсын байцаагчийн хамтарсан 17 албан шаардлага өгч, биелэлтэд хяналт тавин ажиллаж байна. Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэх хугацаа болоогүй.	90
7.9	Үндэсний хэмжээнд эрүүл мэндийн чиглэлээр гэрээний хугацаанд шинээр батлагдсан төлөвлөгөө, хөтөлбөр, арга хэмжээг орон нутгийн түвшинд хэрэгжүүлж, салбар дундын уялдааг ханган хамтарч ажиллана.	-	Хэрэгжүүлж буй хөтөлбөр арга хэмжээний тоо	-	2-3 хөтөлбөр арга хэмжээг хэрэгжүүлж ажиллана.	Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.2.1.14 Сургуульд суурилсан хүүхдийн эрүүл мэндийн эрт илрүүлгийн үндэсний тогтолцоог бий болгох заалтын хүрээнд орон нутгийн түвшинд 26 ЕБС-ийн 1 дүгээр ангийн сурагчдын нийт 1686 хүүхдэд үзлэг хийх 24 эрүүл мэндийн байгууллагын удирдлагууд, 7 шүдний эмнэлгийн захиралуудтай гурвалсан гэрээг байгуулж эрт илрүүлэг үзлэгийг зохион байгуулж хамтран ажиллаж байна.	100
7.10	Засаг даргын зөвлөлийн хурлаар дараах асуудлын хэрэгжилтийг хэлэлцэж, тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэж ажиллана. /Эрт илрүүлэг, оношилгооны явц, Цахимжилт, Кибер аюулгүй байдал,	-	Зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж шийдвэрлэсэн асуудлын тоо	-	2-3 асуудлыг оруулж шийдвэрлүүлсэн байна.	АЗДТГазар цахим хөгжлийн хэлтэстэй хамтран 4 удаа танхимаар, Мөн зүүн бүсийн мэдээлэл технологийн инженерүүдэд цахим хөгжил, кибер аюулгүй байдлын сургалтад ЭМБ-ын мэргэжилтнүүд хамрагдсан. ЭМГазраас статистикч эмч нар болон	100

	мэдээллийн аюулгүй байдал,Төвлөрлийг сааруулах бодлогын хүрээнд аймгийн нэгдсэн эмнэлгийн чадавхийг сайжруулах чиглэлээр авч хэрэгжүүлж буй арга хэмжээ, Хүний нөөцийн тогтвор суурьшил, нийгмийн баталгааг дэмжих чиглэлээрхэрэгжүүлж буй арга хэмжээ/					Мэдээлэл технологийн инженерүүдэд 2 удаа цахимаар сургалт зохион байгуулж, 34 мэргэжилтэн хамрагдсан. Нэн шаардлагатай тусламж, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, төвлөрлийг сааруулах зорилгоор үндэсний багийн гишүүдтэй хамтран ажиллаж байна. Энэ ажлын хүрээнд хавдрын хими эмчилгээг 3-р улирлаас эхлэн орон нутаг хийж эхлэхтэй холбоотой хавдрын химийн эмч, сувилагч, эм найруулагч, ангиографийн техникчийг сургаж, сургалтын төлбөрт дэмжлэг үзүүлсэн.	
7.11	Байгууллагын үйлчилгээний стандарт, төрийн албан хаагчдын хяналтын хуудас хэрэглэх журмын хэрэгжилтийг ханган ажиллана.	Батлагдсан төсвийн хүрээнд	Хяналтын хуудас хэрэглэх журмын хэрэгжилтийн хувь	Хэрэгжилт 100 хувь	Хэрэгжилт 100 хувь	Бүх албан хаагчдад хяналтын хуудас хэрэглэх журмыг танилцуулан хувийн хэрэгт хавсаргасан. Хагас жилийн байдлаар зөрчил гаргасан 2 ажилтны хяналтын хуудас цоолуулж хариуцлага тооцсон.	100
7.12	Тогтвортой хөгжлийн зорилтын хүрээнд байгууллага бүр “Ногоон оффисийн шалгуур”-ыг хангаж ажиллах	-	Шалгуур хангасан байх	100%	100%	Ногоон оффисын шалгуур”-ыг хангах зорилгоор байгууллагын гадна дотор цэцэг тарьж ногоон байгууламж бий болгон ажиллаж байна.	100
7.13	7 хоног бүрийн 4 дэх өдрийн 15:00 цагаас өмнө тухайн 7 хоногт хийсэн ажлын товч мэдээллийг		7 хоног бүр мэдээлэл ирүүлсэн байдал	Тогтмол ирүүлж хэвшээгүй	7 хоног бүрийн 4 дэх өдрийн 15:00 цагийн өмнө мэдээллийг ирүүлж ажилласан байна.	Тухайн 7 хоногт зохион байгуулсан үйл ажиллагааны мэдээллийг 7 хоног бүр тогтмол мэдээллэн ажиллаж байна	100
7.14	Аймгийн удирдлагууд болон харьяа хэлтсийн дарга, мэргэжилтнээс өгсөн хугацаатай үүрэг даалгавар, чиглэлийг хэрэгжүүлж ажиллах		Хугацаанд нь биелэлтийг хангаж ажилласан эсэх		Хугацаанд нь биелэлтийг хангаж ажилласан байх	Хэнтий аймгийн онцгой комиссын даргын 03 тушаалаар байгуулагдсан ажлын хэсгийн бүрэлдэхүүнд эрүүл ахуйн хяналтын 2 улсын байцаагч орж ажилласан. Аймгийн Засаг даргын баталсан удирдамжийн хүрээнд шинээр баригдаж буй 8 барилга байгууламж, 8 худалдаа, үйлчилгээний төвүүдэд хяналт хийж, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах, эрүүл ахуй халдвар	100

[illegible]

ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН

ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ/Д.ДАШНАМЖИЛМАА/

(АЛБАН ТУШААЛ)

(ГАРЫН ҮСЭГ)

.....(ОГНОО)

ТАЙЛАНГ НЭГТГЭСЭН:

ХШҮМХЭЛТСИЙН ДАРГА...../Д.НАРАНМИЧИД/

.....(ОГНОО)